

2019 ОНЫ ТӨСВИЙН БОДЛОГЫН СУДАЛГААНЫ СЭДВҮҮД

	Сэдэв, салбар, төсвийн захирагч	Хамруулах асуудал
<i>Зарим төсөв захирагчийн төсвийн зарлагын судалгаа</i>		
1	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын харьяа Халамжийн сангийн 2017 оны зарлага, 2019 оны зарлагын төлөвлөлтийн судалгаа	<ul style="list-style-type: none"> • Зардлын бүтцийн шинжилгээ хийх • Анхаарал татсан зарлагуудыг сонгож, эдгээр нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг судлах • төрийн аудитийн байгууллагаас тухайн төсөв захирагчийн төсвийн зарлагад хийсэн дүгнэлт, зөвлөмж байгаа эсэхийг зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэхийг судлах • хууль зөрчих нөхцөлд хүргэсэн байж болох шалтгаануудыг тодорхойлох • Төр засгийн зүгээс анхаарах асуудлуудыг дэвшүүлэх • 2019 оны зарлагын төлөвлөлтөд анхаарах асуудлуудыг дэвшүүлэх
2	Нийгмийн даатгалын сангийн 2017 оны төсвийн зарлага, 2019 оны зарлагын төлөвлөлтийн судалгаа	Дээрхтэй ижил асуудлуудыг хамруулна
3	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны төсвийн зарлага, 2019 оны зарлагын төлөвлөлтийн судалгаа	Дээрхтэй ижил асуудлуудыг хамруулна
4	Гадаадын зээл тусламжийн зарим төслийн санхүүжилт, хэрэгжилтийн байдал (Боловсролын салбарт олон жилээр үргэлжилж байгаа 1-2 төслийг сонгон авч, төсвийн зарцуулалтыг судлах)	Дээрхтэй ижил асуудлуудыг хамруулна
5	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 2017 оны төсвийн зарлага, 2019 оны зарлагын төлөвлөлтийн судалгаа	Дээрхтэй ижил асуудлуудыг хамруулахаас гадна нэмэгдэх асуудал: - Үйл ажиллагааны тайланд үндэслэн уг байгууллагын гүйцэтгэсэн ажлын хэмжээ, орон тоо, цалингийн зардал зэргийн талаар судлах
<i>Бодлогын тулгамдсан асуудлаар</i>		

6	Хүнсний аюулгүй байдал ба төсөв	<p>- 2010 онд батлагдсан Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.2. дахь Хүнсний аюулгүй байдал хэсгийн 3.4.2.2. дахь “Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна” гэсэн заалтыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, тэдгээрийн төсвийн судалгаа</p> <p>- Тухайн чиглэлээр 2010 оноос хойш батлагдсан хөтөлбөрүүдийн талаар</p> <p>- Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг 2017-2019 оны төсөвт тусгасан эсэх</p> <p>- Анхаарах асуудлуудыг тодорхойлох</p>
7	Эх, нялхсын эрүүл мэндийн үйлчилгээ ба төсөв	<p>Эх, нялхсын эндэгдлийг бууруулах зорилтыг төр засгийн зүгээс 2016 онд баталсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.3.-т, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.1.7-т, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн. Иймд Энэхүү зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, тэдгээрийн төсвийн зарцуулалт, төсвийн төлөвлөлтийг судлах.</p> <p>- Тухайн чиглэлээр 2010 оноос хойш батлагдсан хөтөлбөрүүдийн талаар</p> <p>- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт энэ чиглэлээр тавьсан зорилтуудыг хангахад төсвийн зарцуулалт чиглэж буй эсэх</p> <p>- Холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг 2017-2019 оны төсөвт тусгасан эсэх</p> <p>- Салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016-2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт дэх чиг хандлага</p> <p>- Анхаарах асуудлуудыг тодорхойлох</p>
8	Тав хүртэлх насны хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээ ба төсөв	<p>Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зорилтыг төр засгийн зүгээс 2016 онд баталсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 3.3.-т “Хүн амын тогтвортой өсөлтийг хангах таатай нөхцөлийг бүрдүүлэх” хүрээнд дэвшүүлсэн. Иймд энэ зорилтыг хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газрын зүгээс хэрэгжүүлсэн хөтөлбөрүүд, тэдгээрийн төсвийн зарцуулалт, төлөвлөлтийг судлах</p> <p>- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт энэ чиглэлээр тавьсан зорилтуудыг хангахад төсвийн зарцуулалт чиглэж буй эсэх</p> <p>- Тухайн чиглэлээр 2010 оноос хойш батлагдсан</p>

		<p>хөтөлбөрүүдийн талаар</p> <ul style="list-style-type: none"> - Холбогдох хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг 2017-2019 оны төсөвт тусгасан эсэх - Салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016-2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт дэх чиг хандлага - Анхаарах асуудлуудыг тодорхойлох
9	Улаанбаатар хотын агаарын бохирдол ба төсөв	<p>Томоохон хот, суурин газарт агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулах зорилтыг “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.3.4-т, “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.3.3-т 2020 он гэхэд Улаанбаатар хотыг утаагүй болгох зорилтыг дэвшүүлсэн. Иймд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр төрийн зүгээс авч хэрэгжүүлсэн арга хэмжээг судлах</p> <ul style="list-style-type: none"> - Тухайн чиглэлээр 2010 оноос хойш батлагдсан хөтөлбөрүүдийн талаар - Хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг 2017-2019 оны төсөвт тусгасан эсэх -2019 оны төсвийн тухай хуульд тусгагдсан хүрэх үр дүнгийн үзүүлэлтүүд (Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцад)-ийн талаар - Анхаарах асуудлуудыг тодорхойлох
10	Монгол Улсын өрийн удирдлага: БНХАУ-д төлөх өрийн судалгаа	<ul style="list-style-type: none"> - БНХАУ-д төлөх өрийн нийт хэмжээ (улсын болон хувийн хэвшлийн) - Зээлийн хүү, эргэн төлөлтийн хуваарь - “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д заасан эдийн засгийн аюулгүй байдлыг хангах зорилттой нийцэж буй эсэх - Анхаарах асуудлуудыг тодорхойлох
11	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилт ба төсөв	<ol style="list-style-type: none"> 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх(ХБХЭ)-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд 2019 онд хэдий хэмжээний төсөв хуваарилсан бэ? Жишээлбэл, туслах багш, тусгай хэрэгцээт боловсролын багш бэлтгэх, ажиллуулах; хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах; тусгай зориулалтын сурах бичгээр хангах зэрэгтэй холбоотой ямар зардал суусан бэ? 2. 2016 онд ХБХЭ-ийн тухай хуулиар тэгш хамруулах боловсролын хэрэгжүүлэх бодлогын чиглэл батлагдсанаас хойш 2017, 2018, 2019 оны Боловсролын сайдын багцад хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааны ямар зардал суусан бэ? Он дараалсан харьцуулалт хийх